



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 685

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 21,299,375.00 (хорин нэгэн сая хоёр зуун ерэн есөн мянга гурван зуун далан таван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгийг Үндэсний геологийн албанд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадагва, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Үндэсний геологийн албаны дарга О.Чулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 4 дугаар сарын 27-ны өдрийн
68... дугаар тогтоолын хавсралт

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮНДЭСНИЙ
ГЕОЛОГИЙН АЛБАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	м.кв	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
			(төгрөг)		
1	Биет бус хөрөнгө, газар эзэмжих эрх-Газар (сонгинохайрхан дүүргийн 29-р хороонд байрлах үйлдвэрийн албан конторын зориулалттай газар)	1602	21,299,375.00	0.00	21,299,375.00
			21,299,375.00	0.00	21,299,375.00
Нийт дүн			(хорин гурван сая хоёр зуун ерэн есөн мянга гурван зуун далан таван)	-	(хорин гурван сая хоёр зуун ерэн есөн мянга гурван зуун далан таван)